



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 584

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 103,151,000.00 (нэг зуун гурван сая нэг зуун тавин нэгэн мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 6 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд болон түүний харьяа байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны...дүгээр...сарын...өдрийн
 584...дугаар тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬЯА
 БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН
 ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

| № | Автомашини марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар | Ашиглалтад орсон огноо | Нийт км | Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл | Худалдах доод үнэ |
|--|---|---------------------------|---------|--|--|
| | | | | /төгрөг/ | |
| 1. Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа | | | | | |
| 1 | Ландкрузейр-80, 8851 ХӨА, арал-HDJ81- 0059234 | 1995 | 308170 | 24,000,000 | 2,000,000 |
| | Дүн | | | 24,000,000 | 2,000,000 |
| 2. Туул голын сав газрын захиргаа | | | | | |
| 2 | Хонда аккорд, УБЗ 62- 79, арал- JHMCCL76405C213124 | 2017 | 129129 | 26,956,000 | 2,500,000 |
| | Дүн | | | 26,956,000 | 2,500,000 |
| 3. Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа | | | | | |
| 3 | УАЗ фургон, ХОУ 2770, арал-74100D0418895 | 2013 | 255250 | 25,500,000 | 600,000 |
| | Дүн | | | 25,500,000.00 | 600,000 |
| 4. Говийн их дархан цаазат газрын хамгаалалтын Б хэсэг | | | | | |
| 4 | Газ-53, 1035 ГАО, арал- 53045841 | 1993 | 176845 | 1,635,000 | 500,000 |
| 5 | УАЗ-31512 5250 ГАА, арал-30555883 | 2000 | 145231 | 12,060,000 | 500,000 |
| 6 | УАЗ-315122, 0050 ГАА, арал-90539544 | 2009 | 139275 | 13,000,000 | 600,000 |
| | Дүн | | | 26,695,000 | 1,600,000 |
| НИЙТ ДҮН | | | | 103,151,000.00 | 6,700,000 |
| | | | | (нэг зуун гурван сая нэг зуун тавин нэгэн мянга) | (зургаан сая долоон зуун мянган) |